

Ганболдын Цэнгүүн^{1,✉}

¹Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Алтайн хадны зургаас томог зангыг хайж тодруулах нь

Товчлол. Алтайн салбар уулс томоохон хадны зургийн цогцолбор дурсгалаар нэн баялаг бөгөөд хадны зурагт дүрслэгдсэн нэгэн дүрслэлийг нэхэн сурвалжилсан болно. Тус дүрслэл нь хадны зургийн аж ахуйн сэдэвт зохиомжийн [Батболд 2014] ан агнуурын дэд төрөлд хамаарагдах занганы дүрслэл бөгөөд Цагаан салаа, Бичигтийн ам, Ловонгийн нуруу, Халхайтын үзүүр гэх мэт олон газраас олдсон байна. Цаашлаад уг дүрслэл биет дурсгал байж болохыг сурвалжлах явцад Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутгаас сонирхолтой нэгэн дурсгал олдсонтой харьцуулсан ба дараагийн удаа тус газарт сорилтын малтлага хийх санал дэвшүүлээ.

Түлхүүр үг: Монгол Алтай, Хадны зураг, Хоморго ав, Дүрслэл, Цогцолбор дурсгал

Tsenguun Ganbold^{1,✉}

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Exploring for the desert kite in Altay's petroglyphs

Summary. The desert kite is well-known archaeological feature in the Middle East and Western Central Asia, but its role in Mongolia is under-examined. This kind of archaeological feature was distributed over a large geographic area and it is not known whether they represent a single widespread tradition or multiple independent traditions. Desert kites have been dated from the Early Neolithic to the Late Bronze and Early Iron Ages. In this paper, we explore the possibility of identifying similar archaeological site in Mongolia based on comparisons with other regions and related petroglyphs in Altay mountains.

Keywords: Altay, Petroglyph, Mass-Hunting, Archaeological imagines, Complex features

Удиртгал


Эртний анчдын занга хэрэглэж байсан ул мөрийг тодруулахад хадны зураг үнэтэй баримт болно. Хадны зураг бол хүн төрөлхтний оюуны сэтгэлгээний анхны бүтээл төдийгүй бичгийн дурсгалтай эн зэрэгцэх түүхэн сурвалжийн нэг юм [Батболд 2014:31].

Монгол орны хадны зургийн цогцолбор дурсгалууд нь Монголын төдийгүй дэлхийд томоохонд тооцогдох байгаль дээрээ хадгалагдан үлдсэн хүн төрөлхтний соёлын үнэт өв бөгөөд хүний хөгжлийн түүхийн олон үеийг нэг дор харуулж байдгаараа онцлогтой [Археологийн өв 2016]. Хадны зургийн цогцолбор дурсгалуудын цөөнгүй хэсэг нь Алтайн салбаруулст харьяалагдах бөгөөд Цагаан салаа, Бага Ойгор, Шивээт хайрхан, Улаанхад, Арал толгой, Их, Бага Хатуугийн гол, Ишгэн толгой, Можоо, Бичигт хад, Цагаан гол, Хойд Сэнхэрийн агуй, Бичигтийн ам, Хавцгайт гэх мэт олон дурсгалт газраар баялаг билээ. Манай улсын хадны зургийн хамрах газарзүйн хүрээ, мэдээллийн сан улам өргөжиж баяжихын хэрээр эртний нүүдэлчдийн аж амьдрал, нийгмийн хөгжлийн олон асуудлыг тодотгох судалгааны эх сурвалжийн тоо тэр хэмжээгээр нэмэгдэж байна.

Алтайн хадны зургийн цогцолбор дурсгалуудад амьтдыг тусгай хэрэгсэл ашиглан агнадаг байсныг харуулсан зохиомжууд бий. Ан авын тэр дундаа хоморго авд хэрэглэгдэж байсан сааль, зангыг дүрсэлсэн зураг олноор тааралдахаас гадна мөн түүнчлэн ан агнуурт хэрэглэж байсан нүсэр чулуун байгууламжийг харуулсан дүрслэл ч мэдэгдэж байна. Дээр өгүүлж буй нүсэр чулуун байгууламж нь Ойрх Дорнодоос биет байдлаар хэдэн мянгаараа олддог “Desert kite¹” бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй судлагдаж байна. Уг дурсгал Ойрх Дорнодоос хадны зургаар болон биет байдлаар багагүй олдож, одоогоор 6000 гаруй тоонд хүрсэн ба цаашид энэ тоо өсөн нэмэгдэх хандлагатай байна [Globalkites 2017]. Desert kite-ийг сүүлийн үед эрт цагт ан авд хэрэглэгдэж байгаад өдгөө орхигдон мартагдсан занганы нэгэн төрөл хэмээн тодорхойлж байна (зураг1).

Энэ зангыг газар орны онцлог тогтцыг ашиглан тусгайлан бэлдэж, зассан чулуугаар байгуулдаг бөгөөд ан амьтдыг олноор нь шахаж авлахад зориулагдсан байдаг. Зөвхөн агаараас харах боломжтой чулуун байгууламжийг [Цэнгүүн

¹ Desert Kite-Цөлийн цаасан шувуу гэсэн утгатай бөгөөд 1927 онд Их Британийн нисгэгч Сирийн газар нутаг дээгүүр нислэг үйлдэх үедээ анх нээн илрүүлжээ. Уг байгууламж агаараас харахад цаасан шувууны хэлбэртэй харагддагаас ийн нэрлэсэн байна. Месопотамийн хөндий, хоёр мөрний сав газар, Уст юртийн өндөрлөг, Зүүн өмнөд Анадолагаас элбэг олддог энэхүү байгууламж нь Өмнөд африкийн Намо Карогоос олдсон нь энэхүү дурсгалын хамгийн өмнөд хязгаар болж байна [Van der Walt, J., Lombard, M 2018].



Зураг 1. Desert kite /агаараас/-Сири улс
[Barge, O et al 2015]

2021:144] монголчууд эртнээс үүрэг зохион байгуулалт, хийц хэлбэрээс шалтгаалан зээгт ав, зээрийн шахаа, “томог занга” хэмээн нэрлэж байжээ. Томог занга нь [Цэнгүүн 2021:260] чулуугаар голдуу хийгдэж, аж ахуйн чухал хэрэгсэл байсан ч түүхэн цаг хугацаанд хэлбэр дүрс, үүрэг зохион байгуулалт нь өөрчлөгдөж цаг хугацаа наашлахын хэрээр чулууг мод, даавуу, уяагаар сольж зарим тохиолдолд олон хүний хүчийг ашиглаж хүн томгийг хийдэг байгаад сүүлдээ бүр мөсөн хорьж, одоо цагт мартагджээ. Томог² занганы эртний хэлбэрийг хадны зургаас харах боломжтой.


Тухайлбал Алтайн салбаруулст харьяалагдах Баянхонгор аймгийн Баянлиг сумын Их Баян уулын Бичигтийн амны хадны зургийн ан агнуурын холбогдолтой хэсэгт хоёр талаас нэн хавчиг зурвас хашаанд нум сум агссан анчид олон буга, янгирыг хөөж буй үйл явцыг харуулсан зурагт дүрслэгджээ [Батболд 2014:81], (зураг 2).

Археологич Н.Сэр-Оджав Увс аймгийн Хархираа голын савд Халхайлтын хүрэн үзүүр гэдэг газрын хадан дээрх зураг дотроос ходоодон томгийн талаар “... хэдэн янгир бугыг хорго татаж, авлаж байгаа сийлбэр байна. Амьтдыг хар хурдаар нь хөөж оруулахад зарим нь хоргонд тулж очсоноо аюуж мэгдэн эргэн зугтаж байгаа байдлыг чадмаг сийлжээ” [Эрдэнэбат 2015:75] гэж бичсэнийг академич Д.Цэвээндорж дахин судлан

² Том, Томог, Томго, Томох, Томорцог, Томголхэмээх “Том” язгууртай эдгээр үгсийн дийлэнх нь ан ав, агнуурын зэмсэг, хашаа хороо, баглах, хумих, хаших, хэрэх, тойруулж бүслэх зэрэг утга ажиглагдаж, цөлийн занганы хашаагаар дамжуулан хорго руу шахах, уужуу амсраас мухар руугаа давчуу болох зэргээр бүтэц, үүрэг зохион байгуулалтаар ижилсэж байгаа нь эртнээс мод болон чулуугаар хийгдсэн энэ төрлийн хоморголох авын зэвсэг хэрэгслийг монголчууд “Томог” хэмээн нэрлэж ирсэн хийгээд энэ мэт агнуурын зэвсгийн төрөл зүйл элбэгшихийн хэрээр олон салаа утга агуулагдан орчин цагт хэрэглээ нь ондоошиж улмаар үндсэн утга нь мартагдан гээгдсэн бололтой [Цэнгүүн 2021:260].



Зураг 2. Бичигтийн амны томог занга
(Д.Содномжамцын хувийн материалаас)



Зураг 4. Ихэр уулын томог занга
[Баасандорж 2018]

Увс аймгийн Тариалан сумын нутаг Хүрэн хадны үзүүрийн нэгэн толигор хаданд арав гаруй янгир, буга зэрэг амьтдыг дүрсэлжээ. Хадны дунд хэсэгт таван янгирын дөрвийг зүүн тийш, нэгийг баруун тийш харуулан дүрсэлсэн байна. Төв хэсэгт том задгай амтай тал хүрээ татаад тэрхүү хүрээнийхээ дунд нарийвтар амтай тусгай булан гаргаж, түүн рүүгээ дөрвөн янгир, нэг бугыг шахан өгч буй мэт дүрсэлсэн нь Монгол болон Евроази, Африкийн ард түмний дунд түгээмэл хэрэглэж ирсэн шахаа, зээгт авыг санагдуулна. Тэрхүү тал хүрээний гадна доод талд бүхий л биеэ сунган харайж яваа ганц янгирыг дүрсэлсэн нь шахаанд оролгүй зугтаж амжаад амь дүйн явна гэлтэй (зураг 3) гэж тодорхойлж хүрлийн үед хамааруулж үзжээ [Цэвээндорж 1999:83].




Зураг 3. Халхайтын үзүүрийн томог занга
(Д.Содномжамцын хувийн материалаас)

Үүнээс гадна Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Ловонгийн нуруу Ихэрийн уулнаас олдсон хадны зурагт хадны гадаргуу олон хагаралттай газарт хашаалсан (хөвөөлсөн) болон задгай талбайд олон тооны хадны зураг зурагджээ.

Хашаалсан хүрээ дотор цан хэлбэрийн малгайтай, нум сум барьсан хүн 3 янгир туусан ба энэ хүрээний дотор анх хүрээ үүсгэж 2 салаа эвэртэй амьтан зурсан нь гэршүүлсэн бололтой. Хүрээний гадна том жижиг амьтад дүрсэлсэн байгаагаас хоёр бугыг тод гаргаж, доод талд адуу, нохой зэрэг дүрслэл байгаагийн нумтай анчныг дүрсэлжээ (зураг 4) гэж тодорхойлсон байна [Баасандорж 2018: 87].

Археологич Н.Сэр-Оджав 1987 онд “Баянлигийн хадны зураг” хэмээх бүтээл хэвлүүлсэн бөгөөд тус бүтээлд Монгол үндэстний уугуул нутгийн нэг болох Ордос нутгийнхны авын ангийн тухай Жамсран авгай нэлээд тодорхой мэдээ үлдээжээ. Авд гарахын өмнө өдөр болзож нэгэн газар цугларах бөгөөд цугларсан анчид ан үргээх, харвах, гал хөсгөө сахих хэсгүүд болж хуваагдах, тусгай тор татаж амьтны гүйдэл хорьдог байжээ. 100-р зурагт байгаа зураас тийм торыг дүрсэлсэн байж болно. Ер нь тор татах, хориг барих зэргээр ан амьтны гүйдэл хорих арга зөвхөн Төв Азид бус өөр орны анчин иргэдэд байжээ. Тухайлбал Индиан-Ирокезүүд тусгай давхар хайс барьж гөрөөс хөөн оруулж агнадаг тухай сонин мэдээ бий



Зураг 5. Баянлигийн томог занга
[Сэр-Оджав 1987]


(зураг 5) хэмээн Баянлигаас олдсон хадны зургийн гар зургийг хавсаргажээ [Сэр-Оджав 1987:44,122].

Цагаан салааны хадны зургийн цогцолбор газарт энэхүү байгууламжийн маш тодорхой зураг бий [Кубарев нар 2005:606]. Тус хаданд ходоод хэлбэрээр тусгайлан бэлдсэн мухар ам бүхий хашаа руу нэг янгир орох гэж байгаагаар, хашааны доод хэсэгт гарц үлдээж, баруун хэсэгт уужим орц /ам/ буйгаар бусад зургаас нэлээд онцлогтой харьцангуй бодитой дүрсэлсэн байна (зураг 6).



Зураг 6. Цагаан салаа голын томог занга
[Кубарев нар 2005]

Монгол Алтайн хадны зургаас олдож буй томог зангатай адилхан дүрслэл бусад бүс нутгаас ч олддог. Сирийн Хеммагийн талаас 11 томог занга, 70 гаруй тооны хадны сийлмэл зураг илрүүлэн олсон бөгөөд 50 орчим зураг нь Khisham-2, үлдсэн зургийг Khisham-1, Kefra зэрэг газраас олсон ба НТӨ III мянганд холбогдуулан үзжээ (зураг 7). Хадны зурагт томог занганы ерөнхий хэлбэр дүрс, бүтцийг маш нарийн гаргаж, өгүүлэмжийн хувьд үхэр, янгир, зээр зэрэг амьтдыг хоолойгоор хөөн, хоргонд шахаж буйгаар, зарим зурагт анчид нум эвшээлгэн намнаж буйгаар чадварлаг дүрсэлсэн байна [Van Berg P.L 2004:95-96].



Зураг 7. Сирийн Кишамын томог занга
[Van Berg P.L 2004].

Үнэхээр эдгээр хадны зургуудыг сайтар ажиглавал Бичигтийн амны хадны зурганд хашлага, Халхайтын хүрэн үзүүрийн хадны зурагт хороо, хороонд залгагдсан үүр, Цагаан салаа голын хаданд дүрслэгдсэн мухар амтай занга, Их бэрх уулын нум агссан анчдын дүрслэл, Ойрх дорнодын хадны зураг болон биетээр олддог томог зангатай нийтлэг шинж чанар, бүтэц болох хашлага, хороо, орц, үүр [Barge.O et al 2015] гэсэн үндсэн хэсэгтэй яв цав нийцэж байгаагаас үзэхэд манай оронд энэхүү занганы төрөл байсан бололтой.

Өмнөх үеийн эрдэмтэд Алтайн хаданд дүрслэгдсэн эдгээр дүрслэлийг чухам юу болохыг эрт цагийн аж байдал, түүхэн уламжлалтай нь зөв харьцуулж, утга агуулгыг бүрэн гаргасан нь илэрхий. Гэвч хаданд үлдсэн дүрслэл хожмын цагт хэрэглэгдэхгүй мартагдсанаас шалтгаалан тухайн дурсгалын судалгаа хийгдсэнгүй бололтой. Тийм дээ ч зарим судлаачид сааль, тор, зам, могой зэргээр тайлбарласан бололтой. Тэгвэл Алтайн уулсын хаданд үлдсэн тус дүрслэл манай оронд бодитоор бий юу? хэмээх сонирхолтой асуулт урган гарч байна.

Археологич Г.Батболд “Нүүдэлчдийн нохой” бүтээлдээ Говийн бүсэд зээрийн шахаа хэмээх газар хэд хэд байх бөгөөд түүний тогтцыг ажиглахад бугын аж ахуйн хашаатай их төстэй байна. Өвөр Монголын Шилийн гол аймгийн Авга хошууны нутагт буй зээрийн шахаа нь бага шиг ханан хадан эргээр хүрээлэгдсэн уулын таг руу амьтан шахааар тогтоцтой байна. Тагийн төгсгөлд 10х50м орчим хэмжээтэй ходоодон хашаа маягтай байгалийн тогтоц байх бөгөөд түүний дутуу хэсгийг чулуу өрөн гүйцээж хийжээ. Уг хашаанд шахан оруулж гацааж намнадаг байсан бололтой. Уг тагийн байгалийн тогтоц нь ирмэгээрээ 2-5м өндөр ханан эргээр хүрээлэгдсэн бөгөөд ханан хад хоорондын амьтан буучихаар жалга маягаар намссан хэсэгт чулуун өрлөг өрж хашсан байна гэж тэмдэглээд тус дурсгалын талаар дэлгэрэнгүй өгүүлсэнгүй холбогдох зургийг нь хавсаргажээ [Батболд 2020]. Үүнээс гадна 2020 онд Улаанбаатарын Их Сургуулийн Түүх, Археологийн тэнхимийн хээрийн судалгааны баг Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт орших Хан уулд археологийн хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд тус хайгуулын хүрээнд Хан уулаас нэгэн сонирхолтой зүйл илрүүлжээ [Идэрхангай 2020:75]. Нутгийн иргэд энэ зүйлийг чулуун далан хэмээн нэрийдэх бөгөөд уулын таг, шилийг дамнуулан цувраа маягаар үйлдсэн байна. Ихэвчлэн 30-50 см өндөр, 40-100см өргөнтэй байх чулуун даланг Хан уулын хэд хэдэн газраас илрүүлжээ. Нутгийн настай хүмүүс “Эрт үед Хан уул нь маш догшин хайрхан байсан бөгөөд түүнийг номхруулж, аргадах


зорилгоор эдгээр чулуун даланг үйлдсэн...” хэмээн тайлбарлаж байсан бол зарим иргэд “Эрт цагт анчид агнасан аргаль янгир зэрэг амьтдыг уулнаас буулгахдаа эдгээр даланг дагуулан өнхрүүлж амар аргаар буулгадаг байсан...” гэх мэтээр аман домог яриануудыг хуучилж байсан хэдий ч энэ нь өөр ямар нэгэн зорилгоор үйлдсэн байгууламж байж болзошгүй мэт санагдана гэж тайлбарлаж, гэрэл зургийг хавсарган “Монголын Археологи” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд оруулжээ [мөн тэнд 76]. Бид уг хурлын эмхэтгэлийг үзээд Хан уулын энэ чулуун далан бидний хайж буй Монгол Алтайн уулсын хадны зурагт дүрслэгдсэн томог занга мөн эсэхийг нягтлахаар 2021 оны 10 сарын 15 нд тус газарт очиж танилцан, чулуун даланд хэмжилт хийж, агаарын болон гэрэл зургийг авч баримтжуулалт хийсэн юм. Үнэхээр бидний хайж буй томог зан биетээрээ олдсон бөгөөд хадны зурган дахь дүрслэл болон Ойрх Дорнодоос олддог Desert Kite-тай олон талаараа ижилсэж байв (зураг 8).



Зураг 8. Хан уулын томог занга /агаараас/


Хан уул нь Даланзадгад хотоос зүүн урагш 24 км орчим зайд орших бөгөөд тал дээр галт уулын хүрмэн чулуулгаас тогтсон олон салаа ам орой тэгш таг бүхий, тарчигхан ургамал, элс голдуу олон үед хамаарагдах хадны зураг болон булштай сондгой хайрхан юм. Эртний нүүдэлчид томог зангыг хийхдээ хавтгай том чулууг хооронд нь налуулан, зарим газраа эгнүүлэн тавиад /газар нэлээд гүн суусан бололтой зарим чулуун дээд ирмэг мэдэгдэх бөгөөд газрын хөрснөөс дээш 20-50 см байна/ завсар зайгаар нь жижиг хэмжээтэй чулууг чигжиж уулын бэлээс ам дагуулан өргөнөөс нарийсах чиглэлтэй өгсүүлж, оройн тэгш таг хэсгээр ирмэгдүүлэн цувруулж, тагны гол руу ойртох тусам нарийсгаж, зарим газраа тасалгаа үүсгэн мухардуулан хийжээ (зураг 9).

Бидний сонгож баримтжуулсан томог занганы гол хэсэгт хүрлийн үед холбогдох дугуй хэлбэртэй дараастай булш байх бөгөөд булшны чулууг байгууламжаас авч ашигласан нь мэдэгдэнэ.



Зураг 9. Хан уулын томог занга /агаараас/

Тиймээс уг занга магадгүй хүрлээс өмнө үед холбогдох бололцоотой хэмээн таамаглаж байна (зураг 10,11). Бид цаг давчуугаас болж зөвхөн Хан уулын салбар хэсгийн нэг томог зангыг баримтжуулсан бөгөөд цаашид уг газарт нарийн судалгаа явуулж Ойрх Дорнодоос олддог томог занга шиг нарийн зохион байгуулалт байгаа эсэхийг судлахаар зорьж байна. Цаашлаад тус байгууламжид малтлага судалгаа хийснээр хэзээнээс ан агнуур туслах аж ахуй руу шилжсэн



Зураг 10. Хан уулын томог занга /булштай/



Зураг 11. Хан уулын томог занганы хана /фото/


бэ? Хүрлийн үе эсвэл неолит магадгүй түүнээс ч өмнө шилжсэн үү? зэрэг олон асуултыг тодруулах боломжтой юм [Өлзийбаяр 2008]. Энэхүү байгууламж нь эртний нүүдэлчид хоморго авд хэрхэн оролцдог байсан, ямар амьтдыг агнадаг байсныг судалж болохуйц чухал хэрэглэгдэхүүн болно. Үүнээс гадна анчин, түүвэрлэгчдийн аж ахуйгаас мал аж ахуй руу шилжих үеийн нийгэмд үзүүлсэн нөлөө, нүүдэлчдийн газар эзэмшилт, хуваарилалт, ашиглалт, монголын мал аж ахуйн үүслийг тодруулж болох юм (Газрын зураг 1).

Дүгнэлт

Алтайн хадны зургийн цогцолбор дурсгалт газрууд нь ан агнууртай холбогдох, ялангуяа амьтдыг үргээж, отох, авлах зэрэг зохиомж, дүрслэлээр баялаг бөгөөд тус сэдэвт зураг дотор агнуурын хэрэгсэлтэй ямар нэгэн байдлаар холбож болохоор зураг тохиолдож байна. Ховор тааралдах эдгээр зургуудыг ахмад үеийн эрдэмтэд ан амьтдыг шахан барих хорго, тор, зээгт авын хэрэгсэл, сааль занга, хашаа гэх мэтээр тайлбарласан

дээр нэмж өөрсдийн боломжид тулгуурлан утга санаа, дүр дүрслэлийн талаар өөр нэгэн саналыг дэвшүүлээ. Зарим нэг хадны зурагт сүрэг амьтдыг хоморголон барихад ашигладаг чулуугаар бэлдсэн байгууламжийг, амьтдыг агнах үйл явцыг хамтад нь тодорхой дүрсэлсэн байна. Уг байгууламжийг нүүдэлчид томог занга хэмээн нэрлэдэг байсан ба ан амьтдыг хоморголон устгах нь хор хөнөөлтэй ихтэй байснаас эрт цагаас цаазлан хорьсноор хэрэглээнээс гарч, улмаар мартагдсаар өдий хүрчээ.

Бид Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Хан уулаас хадны зурганд дүрслэгдсэн томог зангыг биетээр олсон билээ. Тус дурсгал их хэмжээний нутаг дэвсгэрийг хамардаг, сансар, агаараас харагдаж болохуйц том, аливаа дурсгалт газрын орчны судалгаа төдийлөн хийгдээгүй, сурвалжид тэмдэглэгдээгүй зэргээс шалтгаалж өдий хүртэл судлаачдын анхаарлыг татаагүй бололтой. Гэвч дэлхий дахинд уг судалгаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, нийт 6000 гаруйгаар олдож, үүнийг даган сонирхолтой үр дүн, таамаг, санал,



Газрын зураг 1: Томог зангыг дүрсэлсэн хадны зургийн байршил

дүгнэлтүүд гарсаар байгаа нь тухайн дурсгал хэдийн археологийн томоохон судалгаа болсныг харуулж байна. Иймд энэ төрлийн дурсгалын хайгуул, малтлагыг судалгааг эхлүүлж илүү нарийн мэдээллийг цуглуулах саналыг дэвшүүлж байна.

Талархал

Томог зангыг биеэр үзэж, баримтжуулалт хийхэд тусалсан ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан Г.Батболд, Хүрэл, Төмрийн түрүү үеийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан Д.Содномжамц болон тус дурсгалыг анхлан нээн илрүүлж, тодорхойлолт болон гэрэл зургийг нь авч, түүнийгээ харамгүй хуваалцсан Улаанбаатар их сургуулийн багш Т.Идэрхангай, эрдэм шинжилгээний ажилтан Д.Цэнд нарт баярлаж талархсанаа илэрхийлье.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 03 сарын 28

Өгүүлэл засварласан: 2023 оны 04 сарын 17

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 6 сарын 30

Ном зүй

Баасандорж Л. 2018 – Баян-Уулын хадны зураг. Улаанбаатар. т.84, 92

Батболд Г. 2020 – Нүүдэлчдийн нохой I дэвтэр, (Нэн эрт, Хүннү, Эртний улсуудын үе). Улаанбаатар. т.19

Батболд Н. 2011 – Монголын хадны зургийн судалгаа (Говийн бүсийн хэрэглэгдэхүүн), Улаанбаатар, 2011 т.31

Идэрхангай Т., Цэнд Д., Батзориг О. 2020 – Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг дахь Хан уулд явуулсан археологийн хайгуул судалгаа ба түүний хадгалалт хамгаалалтын тулгамдсан асуудал. Монголын археологи. Улаанбаатар. т.75

Кубарев В.Д., Цэвээндорж Д., Якобсон Э. 2005 – Петроглифы Цагаансалаа и Бага-Ойгура (Монгольский Алтай). Новосибирск. т.606

Монголын Хадны зураг, 2016. Эрхэлсэн: Батболд Н. Монголын археологийн өв IV, Улаанбаатар. 2016.

Өлзийбаяр С. 2008 – Монголын хүрэл зэвсэгтний аж ахуйн зарим судалгаа, Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol.4, №1 (312): Улаанбаатар. т. 221, 223

Сэр-Оджав. 1987 – Баянлигийн хадны зураг. Улаанбаатар. т.44, 122.

Цэвээндорж Д. 1999 – Монголын эртний урлагийн түүх. Улаанбаатар. т.83

Цэнгүүн Г. 2021 – Цөлийн занга хэмээх дурсгалын тухайд, Ази судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. vol.8 Улаанбаатар. т.144

Цэнгүүн Г. 2021 – Цөлийн занганы монгол нэршил, Нүүдэлчдийн өв судлал, Том XXII-II, Fasc-22, Улаанбаатар. т.260

Эрдэнэбат У. 2015 – Монголчууд агнуурт занга хэрэглэж байсан нь. – Mongolian Journal of Anthropology Archaeology and Ethnology, Vol. 8, № 1 (403), Улаанбаатар. т. 64, 69, 74-75,

Barge.O., Brochier J. É. and Crassard R, 2015 – Morphological diversity and regionalisation of kites in the Middle East and Central Asia. Arabian Archaeology and Epigraphy 26, 2:162-176.

Van berg P.L., Linden M., Lemaite S., Cauwe N., Picalause V. 2004 – Desert-kites of the Hemma Plateau (Hassake, Syria). In: Paléorient, 2004, vol. 30, №1. pp. 95-96

Van der Walt.J, Lombard.M – Kite-like structures in the Nama Karoo of South Africa., Antiquity Publications Ltd, 2018 antiquity 92 363, e3 (2018): 1–6

GLOBALKITES PROJECT. 2017 – The Global-kites Interactive Map. Archorient. Available from <http://www.globalkites.fr/Interactive-Map>. [Accessed: 3 April, 2017].



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.